

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРТ

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдааны 17 дугаар тэмдэглэлд:

“ХҮИИ.2 Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2016 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан тухай тайлан, үнэлгээний дүнгийн талаар Сангийн сайд Б.Чойжилсүрэн Засгийн газрын гишүүдэд танилцуулав.

Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт үүрэг болгов:

-2016 оны худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээгээр илэрсэн зөрчил дутагдалд дүн шинжилгээ хийж, зөрчлийг давтан гаргахгүй байх, 2017 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны тайлангийн үнэлгээнд хангалттай болон түүнээс дээш үнэлгээ авахаар ажиллах;


-цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн системийг нэвтрүүлэн худалдан авах ажиллагааг 100 хувь цахимаар хийх зорилгоор 2017 оны бүх тендер шалгаруулалтыг цахимаар зарлаж, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд оруулж байх;

-Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулиар батлагдсан урсгал зардал болон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны тендерийн урилгыг 2017 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн дотор зарлаж дуусгах, 6 дугаар сард багтаан тендер шалгаруулалтыг дүгнэж, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан ажлыг нь эхлүүлж 7 дугаар сарын 1-ний өдрөөс хойш гэрээ байгуулахгүй байх;

-өөрийн төсвийн багцад хамаарах захиалагч байгууллагуудын худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тайланд нэгтгэн тусгаж, гарсан зөрчлийг тухай бүр арилгуулах арга хэмжээ авах;

-тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулах аж ахуйн нэгжийн талаарх саналаа тухай бүр Сангийн яаманд хүргүүлж байх;

-худалдан авах ажиллагааны тайлангийн үнэлгээгээр хангалтгүй болон муу үнэлэгдсэн төсвийн ерөнхийлөн захирагч нар холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцон Сангийн яаманд мэдэгдэж байх.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР